



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/Б/15

Хэрлэн сум

Иргэдийн урамшуулалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 06 дугаар, 2022 оны Гучин сая мод хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 07 дугаар, 2023 оны Хорингурав дугаар хуралдааны Аймгийн 2024 оны төсөв батлах тухай 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтий хөтөлбөрийн хүрээнд нийтийн эзэмшлийн цэцэрлэг, ногоон байгууламжид таригдсан модны усалгаа арчилгаа, ургалтын байдалд хөндлөнгийн хяналт тавьж ажиллахаар гэрээ байгуулсан иргэдийн урамшуулалд 18,000,000 (арван найман сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх иргэдийн оролцоот Хэтийн Хэнтий арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, зардлыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шилжүүлж, зарцуулах эрх олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймагт хэрэгжүүлэх ажлын хэсгийн дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\Захирамж-2024

231010785



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 15-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /₮/	Нийт үнэ /₮/
1	Хяналтын ажилд урамшуулал	Хүн/өдөр	20 хүн * 18 өдөр	50,000	18,000,000
	Бүгд			18,000,000	